



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ц.Саранчимэг
Утас: 70273204
И-мэйл: tsaranchimeg@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн өмчийн газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/23/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Орон нутгийн өмчийн газрынтөсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Орон нутгийн өмчийн газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 09-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн ахлах аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Орон нутгийн өмчийн газрын2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 3 дугаар сарын 9-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дүгээр сарын 9-нд Орон нутгийн өмчийн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Компанийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол улсын Засгийн газрын 2016.08.03-ны өдрийн 9-р тогтоолын 4 дүгээр заалтын дагуу Орон нутгийн өмчийн газрын бүтэцийг шинэчлэн зохион байгуулсан. 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн дугаар 57 тоот Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалт газрын үйл

ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлаж орон нутгийн өмчийн газрын салбар нэгжүүдэд мөрдөж ажиллах чиг үүргийг заасан байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь “Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад хууль тогтоомжид заасан холбогдох чиг үүргийг орон нутагт хариуцан гүйцэтгэж ИТХ, Засаг даргад эрхлэх асуудлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгө болон орон нутгийн өмч хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн ИТХурал баталж Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар –ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 28 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 1 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 гэж үзлээ.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Acoullus" програм хангамж ашиглажээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 44878.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Орон нутгийн өмчийн газар 2016 онд 44878.0 мянган төгрөгийн санхүүжилт, урсгал зардалд 44878.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл:

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Орон нутгийн өмчийн газар нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар байгууллагын мэдээллийг оруулаагүй байсныг нөхөж оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 19 эрсдэлтэй асуудалд 19 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Орон нутгийн өмчийн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн

нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 100 хувийг эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

Аудитын явцад материаллаг хэмжээний 630.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тус байгууллагын барилгыг аймаг хүлээж авахдаа цахилгаан ашиглалтын зардлыг тэглэж аваагүйгээс цахилгааны тооцоон дээр маргаантай, 630.2 мянган төгрөгийн цахилгааны өр төлсөн боловч өр авлагын тооцоо нийлсэн актгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дараагийн санхүүгийн жилд цахилгаан тоолуурын маргаантай асуудлыг шийдвэрлэж нэхэмжлэлийг стандарт батлагдсан маягтаар нь авч тооцоог хийж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

2. Цайны газар, Хувийн байгууллага-д /Аудитын компани/ төрийн бус байгууллагууд байрладаг ба түрээсийн гэрээ болон түрээслэх талаар хэрэгжүүлэх журамгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн төсвийн тухай хуулийн 23.7.2-д орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр ... олж, төлөвлөж хэрэгжүүлэх гэснийг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн жил орлого олох үйл ажиллагаа эхлээгүй боловч аудит хийх явцад болон санхүүгийн тайлагналын дараах явцад түрээсийн үйл ажиллагааг эхлүүлсэн боловч гэрээгүй байгаа тул байр түрээслэх журам болон түрээсийн гэрээг байгуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд бүлэг дотроо гүйлгэн зарцуулсан зардлыг тайлагнахдаа бичиг хэргийн зардал 102.4 мянган төгрөгөөр дутуу, шуудан холбоо интернетийн зардал 102.4 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: НББТХ-ийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна гэсний дагуу залруулга хийхээр шийдвэрлэв.

4. Худалдан авах ажиллагааны албаны 392.3 мянган төгрөгийн шуудан холбооны зардлын өглөгийг санхүүгийн тайланд шилжүүлэн бүртгэж

аваагүй байгаа нь НББТХуулийн 8.4-д Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: НББТХ-ийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна гэсний дагуу залруулга хийхээр шийдвэрлэв.

1. Цалингийн зардал, унаа хоолны хөнгөлөлтийн зардал, цэвэр бохир усны зардал, бичиг хэргийн зардал, томилолтын зардал, бараа үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 10224.6 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардлын дансанд хаасан энэ нь Төсвийн тухай хуулийн 8.2-д Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: НБББаримт бичигийг боловсруулан баталж, түүнийг мөрдөж мөнгөн хөрөнгийн зардлыг шууд зардал хаасан бичилт хийлгүй, тооцооны дансаар заавал дамжуулан бүртгэж тайлагнаж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 494.7 мянган төгрөгийн алдаа залруулагдсан болно. Материаллаг бус 10854.8 мянган төгрөгийн алдаа залруулагдаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар эд хариуцагчтай болсон эсэх, түрээсийн төлбөрийн талаар анхаарал татахуйц асуудал байгаа гэж үзэж шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Орон нутгийн өмчийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11349.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс материаллаг 494.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 10854.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2016 оны 9 сард шинээр байгуулагдсан тул өмнөх зөвлөмжийн биелэлт байхгүй болно.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт: Зөрчилгүй санал дүгнэлт

Орон нутгийн өмчийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

	<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>	
<u>ХЯНАСАН:</u>	ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Л.ЖАРГАЛСАЙХАН
	АУДИТЫН МЕНЕЖЕР	О.АМАРЖАРГАЛ
<u>БЭЛТГЭСЭН:</u>	АУДИТОР	Ц.САРАНЧИМЭГ

Огноо: 2017.03.09